



## “БЭРХ УУЛ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 04

Улаанбаатар

Г

Т

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

“Бэрх Уул” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бэрх Уул” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 сарын 28-ны Лхагва гарагт 09:00 цагт Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Модерн Таун хотхон, “Бэрх Уул” ХК-ийн оффисын хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай, Үүнд:
  - a. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах
  - b. 2021 оны ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг хэлэлцэн батлах
  - c. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
  - d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгох
  - e. Компанийн хэлбэрийг өөрчлөх талаар ажлын хэсгээс бэлтгэсэн төслийг хэлэлцэн батлах
  - f. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах.
  - g. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
  - h. Хөрөнгө шилжүүлэх, худалдах тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
  - i. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дугаар сарын 07-ны өдрөөр тогтоосугай.

4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр Хөрөнгийн бирж болон компанийн веб хуудас, 2021 оны 03 дугаар сарын 23-ны “Өдрийн сонин” -д мэдээллэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 04 сарын 07-ны өдөр дахин зарлуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2021 оны 03 сарын 22-ний өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд Хан-уул дүүрэг, 15 хороо, Махатма гандигийн гудамж, Модерн Таун хотхон, 201 тоотод ирж танилцах болон цахим хаягаар хүлээж авах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хуралд биеэр ирж оролцох боломжгүй тохиолдолд цахим хаягт илгээсэн линкээр нэвтэрч хуралд оролцох эрхтэйгээр зохион байгуулсугай.
7. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах өдрийг хүртэл байхаар тогтсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Даваажав, хурал зохион байгуулах комиссын даргаар А.Даваажав, гишүүдээр Н.Содончимэг, Ч.Сарнай, Тооллогын комиссын даргаар Л.Тэмүүжин, гишүүдээр Ө.Наранчулуун, Д.Уянга нарыг тус тус томилсугай

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**Р.БАДРАХ**